



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.БАЯРБАТ ТАНАА

2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн 2014 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Төв аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

И-мэйл

Аудитын менежер

О.Амаржаргал

Утас:70273463

Аудитын багийн ахлах аудитор

Т.Майцэцэг

Ц.Базарсад

Ц.Саранчимэг

Аудитор

О.Сосор

Г.Бадарууган

Ж.Бямбацогт

Шинжээч

Ц.Хишигжаргал

Ч.Батэрдэнэ

Утас: 70273204, 70272287,

70273465

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

- Танилцуулга 1-4
- Гол шийдлүүд 5-23
- Залруулаагүй алдаа 24
- Тайлбар мэдүүлгийн захидал..... 24
- Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... 24
- Аудитын санал дүгнэлт 24

**Төв аймгийн 2013 оны төсвийн гүйцэтгэл болон жилийн
эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн
аудитын газраас аудит хийж дуусгавар
болгосон тухай тайлан**

Бид Төв аймгийн 2013 оны төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Төв аймгийн удирдлага, Санхүү Төрийн сангийн хэлтсийн дарга нарт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Санхүү Төрийн сангийн хэлтсээс хариу ирүүлснийг энэхүү тайланд багцлан тусгасан болно.

Төв аймгийн Удирдлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна.

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулвал:**

Санхүүгийн нэгтгэсэн балансын уялдаа, Орлого санхүүжилт, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, бараа материал, үндсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгө, авлага, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Санхүүгийн гол эрсдлүүд:

Дотоод хяналтын системийг үнэлэхэд доор дурьдсан эрсдлүүд гарах магадлалтай байна Үүнд:

- Татварын орлогыг санхүүгийн нэгтгэсэн тайланд буруу дүнгээр нэгтгэсэн байх Э-1 / Иж, Тол/
- Татварын орлогын нэр төрлийг буруу нэгтгэсэн байх Э-18 /Хэм, Иж, Тол/
- Тусгай сангийн хөрөнгө холбогдох журам зааврын дагуу зарцуулсан эсэх Э-4 /Тох, Тол/
- Мөнгөн хөрөнгийн болон тусгай сангуудын үлдэгдлийг зөрүүтэй нэгтгэж тайлагнасан байх Э-21 / иж бүрэн байх /
- Хөрөнгийн дансдын эхний, эцсийн үлдэгдлийг зөрүүтэй нэгтгэж тайлагнасан байх Э-21 / иж бүрэн байх /
- Авлага өглөгийг болон үлдэгдлийг дутуу буюу буруу нэгтгэж тайлагнасан байх Э-1 / Үнэн зөв байх/
- Батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан, үр ашиггүй зардал гаргасан байх. Э-3 /толилуулга ба илчлэл /
- Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх Э-4 /Үнэн зөв байдал/
- Эдгээр эрсдлүүд байгаа эсэхийг нотлох үүднээс аудитыг төлөвлөн

аудитын холбогдох горимуудыг хэрэгжүүлэхэд эдгээр батламж мэдэгдэл хангагдаагүй зарим зөрчлүүд байна.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсан гол зүйлсийг торуулвал:

1. Санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх орон нутгийн болон аймгийн төвлөрсөн төсвийн татварын орлого ХХОАТатварын буцаан олголтонд олгосон 355.5 сая төгрөгийг хасч тооцсоноор нийт 11415.8 сая төгрөг буюу Татварын хэлтсийн ирүүлсэн татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээнээс 9.0 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн байна.

2. Мөнгөн хөрөнгийн аудитлагдсан оны эхний үлдэгдэл нийт 5872.9 сая төгрөгөөс 0.9 сая төгрөгний зөрүүтэй нэгтгэсэн, эцсийн үлдэгдэл 5121.8 сая төгрөгийг, 5124.1 сая төгрөгөөр буюу 2.3 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн байна.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант онд нийт 63131.2 сая төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 73992.5 сая төгрөг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 10861.3 сая төгрөгийг илүү зарцуулсан байна. Энэ нь ОНӨҮГазрын гүйцэтгэл 5446.6 сая төгрөг, тусгай сангуудын гүйцэтгэл 6725.8 сая төгрөг нийт 12172.4 сая төгрөгийн гүйцэтгэл нь батлагдсан төлөвлөгөөгүйгээр нэгтгэгдсэнтэй холбоотой байна.

4. 2013 оны жилийн эцсийн нийт үндсэн хөрөнгийн 61.1 хувийг, бараа материалын үлдэгдлийн 65 хувийг Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын хөрөнгө эзэлж байна.

5. Бараа материалын эхний үлдэгдэл орон нутгийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитлагдсан эцсийн үлдэгдэл 1205.9 сая төгрөгнөөс 3.1 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн байна.

6. Улсын хөрөнгө оруулалтын дансыг санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэхдээ тайлант оны орлого 678.9 сая төгрөгийн гүйлгээг нэгтгээгүй зөвхөн

оны эхний үлдэгдэл 456.7 сая төгрөгийг хөрөнгийн зардал болгон нэгтгэсэн байна.

7. Авлагын эхний үлдэгдэл орон нутгийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитлагдсан эцсийн үлдэгдэл 3866.7 сая төгрөгнөөс 116.5 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн байна

8. Орон нутгийн хуваарилагдаагүй зардлаас баяр наадмын зардал гаргасан гадаад дотоодын зочин төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлж хүлээн авахад ургацын баярт, Солонгосын зочидыг хүлээн авах зэрэгт 11.1 сая төгрөгийг архи согтууруулах ундаанд зарцуулсан Аймгийн нөөцөнд өвс тэжээл бэлтгэхэд 95.7 сая төгрөгийг зарцуулсан боловч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, аудитаар тайлан тооцоо нь шалгагдаагүй болно.

2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 50929.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 49729.5 сая төгрөгийг аудитын явцад санхүүгийн тайланд нь залруулж, залруулагдаагүй алдаа нь хүлээн зөвшөөрөх түвшингээс бага байгааг үндэслэн Зөрчилгүй санал дүгнэлтийг өгч байна.

Төв аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014 оны 04 дугаар сарын 20 -ний өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан аймгийн СТСХэлтсийн хамт олонд бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

ҮАГазрын харьяа Төв Аймгийн Аудитын Газар

2014.04.19

Танилцуулга

Төв аймгийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 27 сумын орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, ИТХ, ЗДТГазар, Баг зэрэг төсөвт байгууллагууд болон Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Мал хамгаалах сан, Байгал хамгаалах сан, Байгалийн нөхөн сэргээлтийн сан, Эм эргэлтийн сан, ГХУССан зэрэг тусгай сангууд, Орон нутгийн төвлөрсөн төсвийн 86 байгууллага, аймгийн Засаг даргын дэргэдэх 157 тусгай зориулалттай сангуудын болон Орон нутгийн өмчит 2 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Мөн Төсвийн тухай хуулийн дагуу тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд буюу 27 сумын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв байгууллагуудын 120 санхүүгийн тайлан буюу нийт 365 санхүүгийн тайлан нэгтгэгдэн тайлагнагдсан онцлогтой байна.

Төв аймгийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн нотолгоо олж авахын тулд дээрх орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн санал дүгнэлт, зөрчил зөвлөмжинд тулгуурлаж, холбогдох баримт материалыг үзэж асууж танилцах, өмнөх оны аудитлагдсан дансдын үлдэгдлийг тулгах, тайлант оны төлөвлөгөөтэй зэрэгцүүлэн судалгаа хийх, тулган баталгаажуулах, санхүүгийн нэгтгэсэн тайлангаас түүвэрлэх, балансын уялдааг дахин хянах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлэн ажилласан.

Төв аймгийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж дууссан тухай Дуусгавар болсон тайланг аймгийн Засаг дарга, Санхүү Төрийн Сангийн Хэлтсийн дарга нарт өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаар бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Санхүү Төрийн сангийн хэлтэс нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Нэг: Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

Төв аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь аймгийн нэгтгэсэн тайлангийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид аймгийн Засаг дарга болон Санхүү төрийн сангийн хэлтсийн даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан. Дараах түвшний

хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд аймгийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Төв аймгийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг санхүүгийн тооцоолох төвийн Пластик нэгтгэлийн программаар нэгтгэн тайлагнасан байна. Нэгтгэсэн тайлан балансын уялдааг тулган шалгахад:

✓ Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгө ба активын дүн оны эхэнд 39880.1 сая төгрөг, оны эцэст 108727.5 сая төгрөг, нийт эх үүсвэр ба пассивын дүн оны эхэнд 39880.1 сая төгрөг, оны эцэст 141360.5 сая төгрөг байна. Энэ нь актив пассив оны эхэнд 35.7 мянган төгрөг, оны эцэст 32633.0 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдэж тайлагнасан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдлын тайлангийн актив пассивын зөрүүг тодруулахад Боловсрол Соёл Шинжлэх ухааны сайдын багцын оны эцсийн зөрүү 6.2 сая төгрөг, Орон нутгийн багцын оны эцсийн зөрүү 32626.8 сая төгрөг байсныг залруулсан.

✓ *Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл:* Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдлын тайлангаар оны эхэнд 5873.8 сая төгрөг, оны эцэст 5099.1 сая төгрөг байхад мөнгөн гүйлгээний тайлангаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь оны эхэнд тохирсон ба оны эцэст 50.1 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулсан. 2013 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл 5873.8 сая төгрөг нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар мөнгөн хөрөнгийн аудитлагдсан үлдэгдэл нийт 5872.9 сая төгрөгөөс 0.9 сая төгрөгний зөрүүтэйг залруулаагүй нэгтгэгдсэн.

✓ *Авлага:* Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдлын тайлангаар оны эхэнд 3750.2 сая төгрөг, оны эцэст 8455.2 сая төгрөг оны эхнээс 4705.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Авлагын эхний үлдэгдэл орон нутгийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитлагдсан эцсийн үлдэгдэл 3866.7 сая төгрөгнөөс 116.5 сая төгрөгөөр зөрүүтэйг залруулаагүй нэгтгэгдсэн.

✓ *Өглөг:* Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдлын тайлангаар оны эхэнд 1357.5 сая төгрөг, оны эцэст 1512.3 сая төгрөг оны эхнээс 154.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өглөгийн эхний үлдэгдэл орон нутгийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тохирч байна.

✓ *Бараа материал:* Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдлын тайлангаар оны эхэнд 1209.1 сая төгрөг, оны эцэст 4084.4 сая төгрөг оны эхнээс 2875.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Бараа материалын эхний үлдэгдэл орон нутгийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитлагдсан эцсийн үлдэгдэл 1205.9 сая төгрөгнөөс 3.1 сая төгрөгөөр зөрүүтэйг залруулаагүй нэгтгэгдсэн.

✓ *Үндсэн хөрөнгө:* Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдлын тайлангаар оны эхэнд 28987.2 сая төгрөг, оны эцэст 90802.3 сая төгрөг оны эхнээс 61815.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгийн эхний

үлдэгдэл орон нутгийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тохирч байна

✓ *Нэмэлт санхүүжилтийн орлого*: Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд 1156.0 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн тайланд 1138.0 сая төгрөг буюу 18.0 сая төгрөгөөр зөрүүтэйг залруулаагүй. *Нэмэлт санхүүжилтийн тайлангаар эх үүсвэр* 1138.0 сая төгрөг, зарлага 1067.0 сая төгрөг зөрүү буюу үлдэгдэл 71.0 сая төгрөг нь уг тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 69.0 сая төгрөгөөр буюу 2.0 сая төгрөгөөр зөрүүтэй.

Тайлан балансын уялдааг тулган шалгахад нийт 49874.3 сая төгрөгийн алдаа илэрснийг харилцагч байгууллагад залруулахаар санал болгосныг аудитын явцад 49729.5 сая төгрөгийн алдааг хүлээн зөвшөөрч залруулсан.

2. Орлого эх үүсвэрийн талаар

Аймгийн төвлөрсөн төсвийн орлого эх үүсвэр, түүнийг баталсан болон тодотгосон эрх зүйн баримтыг тулган шалгахад аймгийн 2013 оны төсвийн орлогыг Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 2-р хуралдааны 05 тоот тогтоолоор нийт дүнгээр 60550.5 сая төгрөгөөр баталсан ба 2013 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 6-р хуралдааны 01 тоот тогтоолоор 61768.9 сая төгрөгөөр тодотгон баталсан байна. Үүнд:

1. Аймгийн төвлөрсөн төсвийн урсгал орлогыг 9376.6 сая төгрөг
2. Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 9207.2 сая төгрөг
3. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 7621.6 сая төгрөг
4. Хандив тусламжийн орлого 1090.1 сая төгрөг
5. Тусгай зориулалтын шилжүүлэг 32626.8 сая төгрөг
6. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын өөрийн орлого 46.1 сая төгрөг
7. Аймгийн төсвийн шилжих үлдэгдэл 1531.6 сая төгрөг
8. Аймгийн төсөвт байгууллагуудын төсвийн хэмнэлтийн үлдэгдэл 268.9 сая төгрөг тус тус баталсан байна.

Орон нутгийн төсвийн урсгал орлогыг 27 сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоолоор 1287.3 сая төгрөгөөр баталж, тодотгосон.

Төв аймгийн Татварын хэлтсийн ирүүлсэн мэдээгээр батлагдсан төлөвлөгөөгөөр орон нутгийн болон аймгийн төвлөрсөн төсвийн орлогоор ХХОАТатварын буцаан олголтонд 355.5 сая төгрөгийг хасч нийт 10664.0 сая төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр нийт 11424.8 сая төгрөгийн орлого төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 760.8 сая төгрөгөөр илүү буюу 107.1 хувиар давж биелэсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзэхэд 24 нэр төрлийн орлогоос 20 нэр төрлийн орлого 101.9-476.9 хувиар биелэсэн ба Ус рашааны нөөц ашигласны төлбөр 278.3 сая төгрөгөөр буюу 15.1 хувиар, байгалийн ургамал ашигласны төлбөр 1.9 сая төгрөгөөр буюу 59.2 хувиар, үйл ажиллагааны орлого 132.0 сая төгрөгөөр буюу 37.9 хувиар нийт 4 нэр төрлийн орлого 15.1-59.2 хувиар тасарсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх орон нутгийн болон аймгийн төвлөрсөн төсвийн татварын орлого ХХОАТатварын буцаан олголтонд

олгосон 355.5 сая төгрөгийг хасч тооцсоноор нийт 11415.8 сая төгрөг буюу Татварын хэлтсийн ирүүлсэн татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээнээс 9.0 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн байна.

Аймгийн төвлөрсөн төсвийн буюу орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг тусд нь тооцоход аймгийн төвлөрсөн төсвийн орлогоор 9376.6 сая төгрөг төвлөрүүлэхээр батлагдсанаас, гүйцэтгэлээр татварын буцаан олголт 355.5 сая төгрөгийг хасч тооцвол нийт 9816.7 сая төгрөгийн орлого төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 440.0 сая төгрөгөөр буюу 104.7 хувиар давж биелэсэн байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөг 20 сум 0.8-52.2 хувиар давуулан биелүүлж, Баянхангай, Баянжаргалан, Борнуур, Заамар, Мөнгөнморьт, Сүмбэр, Сэргэлэн зэрэг 7 сум 0.1- 30.0 хувиар тус тус тасалсан байна.

Орон нутгийн төсвийн урсгал орлогоор батлагдсан төлөвлөгөөгөөр 1287.3 сая төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 1608.1 сая төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 320.8 сая төгрөгөөр буюу 124.9 хувиар давуулан биелүүлсэн байна. Сумын орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын төлөвлөгөөг 21 сум 100.4-222.9 хувиар давуулан биелүүлж, Аргалант, Баян-Өнжүүл, Баянхангай, Бүрэн, Угтаал, Эрдэнэсант зэрэг 6 сум 1.7-29.3 хувиар тасалсан байна.

Аудитын явцад Татварын хэлтсийн мэдээг, сумдын гаргасан төсвийн орлогын гүйцэтгэл, Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэсэн орлогын дүнтэй зэрэгцүүлэн судалгаа хийж, тулган шалгахад Татварын орлогыг Зуунмод сум 1.1 сая төгрөгөөр, Баяндэлгэр сум 1.7 сая төгрөгөөр илүү мэдээлсэн, 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Баянцагаан сум 6.6 сая төгрөгөөр, Бүрэн 1.7 сая төгрөгөөр, Сэргэлэн сум 7.4 сая төгрөгөөр, Алтанбулаг, Архуст, Баян, Мөнгөнморьт, Баянхангай сумд 0.1-0.5 сая төгрөгөөр илүү нэгтгэсэнээр Татварын хэлтсийн мэдээний дүн болон санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орлого зөрүүтэй нэгтгэгдсэн байна.

Сумдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбогдсон дараах зөрчил илэрлээ. Үүнд: Орон нутгийн төсвөөс сумын ИТХурлын тогтоол шийдвэргүйгээр Борнуур сум нь 5.2 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сандаа, Дэлгэрхаан сум нь 2.5 сая төгрөгийг Мал хамгаалах сандаа тус тус шилжүүлэн зарцуулсан.

Төсвийн тухай болон татварын тухай хуулийн дагуу орон нутгийн орлогот төвлөрүүлэх хог хаягдлын хураамжийг Дэлгэрхаан сум 0.8 сая төгрөгийг сумын Байгал хамгаалах сандаа төвлөрүүлж зарцуулсан, Заамар сум 2.1 сая төгрөгийг иргэн н.Рагчаагийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан, Зуунмод сум түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.5 сая төгрөгийг сумын Байгал хамгаалах санд төвлөрүүлсэн байна.

Тайлант онд батлагдсан төлөвлөгөөний дагуу улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 9207.2 сая төгрөгийг авсан ба Орон Нутгийн Хөгжлийн санд 7621.6 сая төгрөгийн санхүүжилт авахаас 6924.1 сая төгрөг санхүүжигдэж, батлагдсан төлөвлөгөөнөөс 697.5 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 32626.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдснаас, гүйцэтгэлээр 32626.8 сая төгрөгний

санхүүжилтийг авч зарцуулсан байна. Өөрийн орлого төлөвлөгөөгөөр 46.1 сая төгрөг батлагдснаас, гүйцэтгэлээр 153.0 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Тайлант онд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 27 сумын Сум хөгжүүлэх санд нийт 1700.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон, ба 2012 онд олгох сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 220.0 сая төгрөгийг аймаг хөгжүүлэх санд үлдэгдлээр тайлагнасан байсныг тайлант онд Эрдэнэсант суманд 60.0 сая төгрөг, Баянчандмань суманд 60.0 сая төгрөг, Өндөрширээт сум 50.0 сая төгрөг, Дэлгэрхаан сум 50.0 сая төгрөг тус тус санхүүжилтийг олгосон байна

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар 1138.0 сая төгрөгийн эх үүсвэр буюу 1067.0 сая төгрөгийн зардлыг нэгтгэж тайлагнасан ба орлого, зарлагын зөрүү 71.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлагнагдахаас 69.0 сая төгрөгөөр буюу 2.0 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Цаг хугацааны байдлаас шалтгаалан нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр болон зардлыг тулган баталгаажуулаагүй болно,

3.Төсвийн гүйцэтгэлийн талаар

Төв аймгийн 2013 оны төсвийн нийт зарлагыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 2-р хуралдааны 05 тоот тогтоолоор 60550.5 сая төгрөгөөр баталсан ба аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 6-р хуралдааны 01 тоот тогтоолоор 61768.9 сая төгрөгөөр тодотгон баталсан байна. 27 сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоолоор сумын орон нутгийн төсвөөс болон давсан орлогоос зарцуулах зарлагын төлөвлөгөөг баталдаг байна.

Төв аймгийн Засаг даргын өргөн барьсан 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвийн нийт гүйцэтгэл төлөвлөгөө 90052.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 107098.9 сая төгрөг гэж нэгтгэгдэж, батлагдсан төлөвлөгөөнөөс 17046.4 сая төгрөгөөр хэтэрсэн байсныг аудитын явцад тулган баталгаажуулалт, асуулга тодруулга хийхэд төсвийн гүйцэтгэлийн тайланг программаас буруу сонгож хэвлэсэн гэсэн тайлбараар буюу 2014 оны 04 дүгээр сарын 16-ний өдөр дахин залруулж ирүүллээ. Энэ тайлангаар тайлант онд 63131.2 сая төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 73992.5 сая төгрөг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 10861.3 сая төгрөгийг илүү зарцуулсан байна. СТСХэлтсийн ирүүлсэн тайлбар тодруулгаар Орон нутгийн өмчит үйлдвэрийн 2 газрын гүйцэтгэл 5446.6 сая төгрөг, тусгай сангуудын гүйцэтгэл 6725.8 сая төгрөг нийт 12172.4 сая төгрөгийн гүйцэтгэл нь батлагдсан төлөвлөгөөгүйгээр нэгтгэгдсэн байна.

Үүнийг хасч тооцвол 1311.1 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна. Үүнд: 2013 оны төсвийн гүйцэтгэлийн бүлгийн дүнгээр авч үзэхэд Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардал 355.3 сая төгрөгөөр, НДШимтгэлийн зардал 58.8 сая төгрөгөөр, хэмнэлттэй, татаас урсгал шилжүүлэг 941.7 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 522.6 сая төгрөгөөр тус тус хэмнэлттэй, бараа үйлчилгээний урсгал зардлыг 567.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулвал: / сая төгрөг/

Үзүүлэлт	Төсөв	Тайлант он	хэтрэлт/-/ хэмнэлт/+
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,131.23	61,820.10	1,311.1
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	63,131.23	61,820.10	1,311.1
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	54,051.98	53,263.51	788.5
Бараа, үйлчилгээний зардал	44,746.04	44,899.26	(153.2)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,724.84	26,369.57	355.3
Үндсэн цалин	23,443.51	23,318.31	125.2
Нэмэгдэл, урамшил	640.68	567.26	73.4
Гэрээт ажилчдын цалин	1,278.00	1,207.19	70.8
Унаа хоолны хөнгөлөлт	34.28	28.74	5.5
Үр дүнгийн урамшуулал	1,328.36	1,248.07	80.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,941.81	2,882.98	58.8
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	15,079.40	15,646.71	(567.3)
Тогтмол зардал	5,412.09	5,210.03	202.1
Гэрэл цахилгаан	502.24	508.88	(6.6)
Төлш, халаалт	4,800.39	4,594.45	205.9
Цэвэр, бохир ус	109.46	106.70	2.8
Бараа, үйлчилгээний бусад зардал	9,667.31	10,436.69	(769.4)
Бичиг хэрэг	98.25	105.21	(7.0)
Тээвэр (шатахуун)	672.18	739.26	(67.1)
Шуудан холбоо	83.71	82.47	1.2
Дотоод албан томилолт	240.36	241.24	(0.9)
Гадаад томилолт /арга хэмжээ/	30.00	16.53	13.5
Ном хэвлэл авах	43.96	40.94	3.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	86.61	85.90	0.7
Сургалт, семинарын зардал	22.87	30.02	(7.1)
Эд хогшил худалдан авах	85.28	167.16	(81.9)
Нормын хувцас зөөлөн эдлэл	89.07	89.36	(0.3)
Хоол	2,312.23	2,255.14	57.1
Эм	235.09	233.34	1.7
Урсгал засвар	197.72	320.15	(122.4)
Урлагын уран бичлэлийн зардал	82.00	78.63	3.4
Төлбөр хураамж болон бусад зардал	156.00	218.64	(62.6)
Гадаад зочны зардал	3.96	3.82	0.1
Биеийн тамирын уралдаан тэмцээн	67.50	66.14	1.4
Аж ахуйн материал худалдан авах зардал	1.69	2.61	(0.9)
Холбооны суваг ашигласны хөлс	5.79	5.87	(0.1)
Байрны тїрээсийн зардал	2.51	1.21	1.3
Төвлөрсөн арга хэмжээ	56.43	198.55	(142.1)
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	-	293.87	(293.9)
Гэмт хэргээс сэргийлэх арга хэмжээний зардал	80.53	77.90	2.6
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	1,153.73	886.65	267.1
Соёл урлаг хөгжүүлэх зардал	0.01	0.01	-
Хот суурингийн өрөнхий төлөвлөгөөний зардал	0.05	0.05	-
Газрын зургийн зардал	4.00	5.00	(1.0)
Гудамжны гэрэлтүүлэг	70.00	70.00	-
Харуул хамгаалалтын зардал	-	3.93	(3.9)
Ажил үйлчилгээний хөлс	3.00	1.62	1.4
Төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардал	-	7.04	(7.0)
Баяр наадмын зардал	8.18	16.83	(8.7)
Шагнал, тэтгэмжийн зардал	7.28	8.69	(1.4)
Засварын зардал	-	0.02	(0.0)
Маягт хэвлэх зардал	0.38	1.28	(0.9)
ЦАУЗБК-ын зардал	3.00	2.97	0.0
Бусад зардал	276.80	288.14	(11.3)

ТӨВ АЙМГИЙН 2013 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БОЛОН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Бусад нэр төрлийн хувиарлагдаагүй	2,168.65	1,927.19	241.5
Банкны йлчилгээний хураамж	1.07	1.11	(0.0)
Улсын тооллогын зардал	0.30	0.51	(0.2)
Ногоон хувьсгалын хөтөлбөрийн зардал	4.93	4.93	-
INTELSAT ба RETURERS-ийн суваг ашигласны төлбөр	0.47	0.36	0.1
Хичээл, йлдвэрлэлийн дадлага, сургуулилт	79.75	76.58	3.2
Сургалт, семинар зохион байгуулах зардал	0.45	0.45	0.0
Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон зардал	231.18	231.25	(0.1)
Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх	4.01	4.01	-
Эмнэлгийн ажилтаны мэргэжил дээшлүүлэх зардал	0.27	0.18	0.1
Мал эмнэлгийн йлчилгээний зардал	350.00	341.60	8.4
Сумдад төрийн захиргааны ажилтан бэлтгэх	38.09	38.09	-
Уран бйтээл хийлгэх, бэлтгүүлэх	-	9.00	(9.0)
Төрийн өмнөөс гйцэтгүүлсэн ажил йлчилгээ	137.11	176.84	(39.7)
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох йлчилгээний хөлс (гадаад)	11.25	10.55	0.7
Банк, санхйгийн байгууллагын йлчилгээний хураамж	3.25	2.37	0.9
Аудит, зэрэглэл тогтоох йлчилгээний хөлс (дотоод)	3.41	2.30	1.1
Эд хөрөнгийн даатгал	3.59	2.83	0.8
Тээврийн хэрэгслийн даатгал	8.85	5.58	3.3
Галын даатгал	0.67	0.56	0.1
Харуул, хамгаалалтын хөлс	2.85	2.85	-
Тээврийн хэрэгслийн оношилгоо	3.68	2.21	1.5
Мэдээлэл сурталчилгааны зардал	10.70	33.28	(22.6)
Газрын төлбөр	1.50	-	1.5
Хог хаягдал устгах, цэвэрлэх	50.99	55.72	(4.7)
Бусад зардал	312.19	799.51	(487.3)
Дотоодын эх йсвэрээс санхйжүүлж байгаа	57.96	60.65	(2.7)
Татаас ба урсгал шилжүүлэг	9,305.94	8,364.25	941.7
Татаас	-	4.00	(4.0)
Өндөр настны тэтгэвэр	177.76	174.81	2.9
Хөдөлмөрийн чадвар тйр алдсаны тэтгэмж	-	1.58	(1.6)
Жирэмсэн амаржсаны эхийн тэтгэмж	738.02	279.71	458.3
Халамжийн тэтгэвэр	4,024.54	4,051.64	(27.1)
Жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмж	1,140.96	1,067.65	73.3
Халамжийн бусад хөнгөлөлт-йлчилгээ	0.69	0.69	-
Хйхдэд олгох мөнгөн тэтгэмж	0.69	0.69	-
Олон нийтийн оролцоонд тйшиглэсэн халамжийн йлчилгээ	34.34	38.49	(4.1)
Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж	412.03	233.83	178.2
Хоол тэжээлийн тусламж, дэмжлэг	505.20	217.46	287.7
Тэтгэвэрийн нөхөн олговор	22.71	23.47	(0.8)
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	209.16	234.91	(25.8)
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	819.32	776.46	42.9
Ээлжийн амралтаар нутаг явах унааны зардал	0.80	-	0.8
Нэг удаагийн буцалтгүй тусламж	29.06	33.32	(4.3)
Шагнал, урамшил	17.76	15.31	2.4
Сонгуулийн йр дйнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор	-	8.50	(8.5)
Хөдөө, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох тэтгэмж	431.03	413.34	17.7
Йдийн цай	628.85	596.85	32.0
Төлбөр, хураамж	13.04	12.30	0.7
Гадаад шилжүүлэг	100.00	179.27	(79.3)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,079.24	8,556.60	522.6

Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой аудитаар илэрсэн асуудлууд:

1. Замын сангийн харилцах данс нь 20.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй тайлант онд 204.5 сая төгрөгийн эх үүсвэр болон 224.9 сая төгрөгийн зарлагыг нэгтгэсэн байна. Аудитын явцад харилцах дансны орлого, зарлагын хуулгыг авч шалгахад орон нутгийн орлогоос 160.6 сая төгрөгийн санхүүжилт, 32.0 сая төгрөгийн замын сангийн хураамж нийт 160.7 сая төгрөг төвлөрсөн байхад зарлагын дэлгэрэнгүй хуулгаар 300.4 сая төгрөгийн зарлага гарсан байгааг үндсэн баримт үзүүлээгүй тул нотолж чадаагүй болно.

2. Төрийн сангийн бүртгэлийн дансны хуулгаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барилга, байгууламжийн дансны үлдэгдэл 372.1 сая төгрөг, их засвар, тоног төхөөрөмжийн дансны үлдэгдэл 84.6 сая төгрөг нийт 456.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Тайлант онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барилга байгууламжийн 140051301 тоот дансанд Зам тээврийн яамнаас 31.0 сая төгрөгийн санхүүжилт, ХАХөдөлмөрийн Яамнаас ахмадын сувилалын 647.9 сая төгрөгийн санхүүжилт, нийт 678.9 сая төгрөгийн орлого төвлөрч, 1051.0 сая төгрөгийн зарлага гарсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын их засварын 140051302 тоот дансны оны эхний үлдэгдэл 84.5 сая төгрөгнөөс Эрдэнэсант сумын Соёл спортын төвийн барилгын санхүүжилтийг /Төвцогт- өлзийт ХХК-д 47.3 сая төгрөгийг, Барилга хот байгуулалтын албаны дансанд 34,8 сая төгрөгийг/, Газрын албанд техник хяналтын зардалд 2.4 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлж үлдэгдэлгүй байна. Тус дансыг санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэхдээ тайлант оны орлого 678.9 сая төгрөгийн гүйлгээг нэгтгээгүй зөвхөн оны эхний үлдэгдэл 456.7 сая төгрөгийг хөрөнгийн зардал болгон нэгтгэсэн байна.

3. Орон нутгийн хөрөнгө оруулалтын 140051300 тоот дансны оны эхний үлдэгдэл 226.9 сая төгрөг, 760.3 сая төгрөгийн орлого, 1070.5 сая төгрөгийн зарлага гарч 83.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байхаас үлдэгдэлгүй тайлагнасан байна.

4. Хот байгуулалт барилга албаны 140051002 тоот дансны оны эхний үлдэгдэл 4.3 сая төгрөг, 370.4 сая төгрөгийн орлого, 374.7 сая төгрөгийг зарцуулж мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд орлогыг 284.5 сая төгрөгөөр буюу 85.9 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн

Дээрх дансдуудын зардлын гүйцэтгэлийг аудитын явцад шалгуулаагүй тул ямар зардалд, зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг нотлох боломжгүй байлаа.

5. Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц орон тоонд Цэргийн штаб багтдаг. Цэргийн штаб нь төрийн санд 140051026 тоот дансанд 56.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 70.7 сая төгрөгийн орлого, 127.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээр санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдсэн байна. Төрийн сангийн төлбөр тооцооны журмын 1.2.4 дахь заалт, Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монгол банк, банкинд нээх, хаах журамын 1.2.4 дахь заалтуудыг зөрчиж байгаа тул Хувиарлагдаагүй зардал, цэргийн штабын дансуудыг хаах арга хэмжээ авахыг санал болгож байна.

6. Хуваарилагдаагүй зардлын харилцах данс нь оны эхэнд 0.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 1942.1 сая төгрөгийн орлого орж, 1942.3 сая төгрөгийг зарцуулж оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны төсөв батлах тухай 05 тоот

тогтоолоор орон нутгийн хуваарилагдаагүй зардал 105.0 сая төгрөгөөр баталсан ба тодотголоор 32.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 137.6 сая төгрөгөөр, аймгийн шилжих үлдэгдэлийг 1531.6 сая төгрөгөөр, аймгийн төсвийн хэмнэлтээс зарцуулах зарлагыг 268.9 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Аймгийн 2013 оны төсвийн тодотгол батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 01 тоот тогтоолоор орон нутгийн хуваарилагдаагүй зардлыг 230.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 368.4 сая төгрөгөөр, аймгийн шилжих үлдэгдэлээс зарцуулах зарлага 1531.6 сая төгрөг, аймгийн төсвийн хэмнэлтээс зарцуулах зарлага 268.9 сая төгрөг, нийт 2168.9 сая төгрөг баталсан байна. Уг данснаас тайлант онд 1919.5 сая төгрөгний санхүүжилт авч батлагдсан төлөвлөгөөнөөс 249.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна. Энэхүү дансанд үйл ажиллагааны орлогоор 22.6 сая төгрөгийн орлого орсноос 12.6 сая төгрөгийн орлого нь нэр данс зөрүүтэй буцсан гүйлгээ байна. Зарцуулалтыг бүтцээр нь авч үзвэл

- ✓ Иргэний танхимын барилга, тоног төхөөрөмж ажилтнуудын цалин шимтгэл үйл ажиллагааны нийт зардал 109.5 сая төгрөг,
- ✓ Аймгийн Прокурорын барилгын засвар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зам тавих ажил, Баянчандмань сумын халаалтын зуухны засвар, аймгийн Засаг даргын орлогчийн өрөөний засвар, Монгол туургатан театрын засвар, Худалдан авах ажиллагааны албаны засварт 74.5 сая төгрөг,
- ✓ Цасанд дарагдсан газар нутаг дахь мал сүрэгт бэлчээрлэх талбай гаргах, хаагдсан зам талбайг онгойлгох зорилгоор Онцгой байдлын газарт 13.7 сая төгрөг
- ✓ Сумдын багийн Засаг дарга нар болон Засаг даргын орлогч нарт тэтгэмжинд 287.7 сая төгрөг
- ✓ Аймгийн ЗДТГазар, Цагдаагийн газар, Хот тохижуулах газруудад автомашин, Архуст, Баян-Өнжүүл, Сэргэлэн сумдын төрийн албан хаагчдийн орон сууц, Төрийн болон ТББайгууллагууд байрлах байрны засвар, төрийн болон төрийн бус байгууллагат олгосон сургалт семинарын зардал зэрэгт 560.8 сая төгрөг,
- ✓ Нийтийн биеийн тамирын арга хэмжээнд 20.0 сая төгрөг,
- ✓ Төсөвт байгууллагуудад өр шийдвэрлэхэд 146.0 сая төгрөг ,
- ✓ Аймгийн нөөцөнд өвс тэжээл бэлтгэх зардалд 95.7 сая төгрөг,
- ✓ Гадаад томилолт болон гадаад арга хэмжээний зардалд 75.5 сая төгрөг,
- ✓ Аймгийн 90-н жилийн ойн баяр наадмын зардалд 546.4 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Орон нутгийн хуваарилагдаагүй зардлаас баяр наадмын зардал гаргасан гадаад дотоодын зочин төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлж хүлээн авахад ургацын баярт, Солонгосын зочидыг хүлээн авах зэрэгт 11.1 сая төгрөгийг архи согтууруулах ундаанд зарцуулсан байна.

Аймгийн нөөцөнд өвс тэжээл бэлтгэхэд 95.7 сая төгрөгийг зарцуулсан боловч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, аудитаар тайлан тооцоо нь шалгагдаагүй болно.

Энэ дансны хувьд санхүүгийн тайлан баланс гаргаагүй зөвхөн мөнгөн хөрөнгийн журнал, харилцах дансны гүйлгээний хувьд аудит хийгдлээ.

Аудитын явцад төсвийн зарцуулалттай холбогдсон дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

➤ Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн сангийн төлөөлөгч нар нь алдаатай гүйлгээ баталгаажуулснаас буцсан гүйлгээ ихээр гардаг, анхан шатны баримтын бүрдүүлэлт, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа хяналт муу тавьдаг, Бүлэг хооронд шилжүүлэхдээ ЗЭБ маягтыг хөтөлдөггүй, ЗДТГазрын харилцах дансаар дамжуулах үүрэгтэйгээр /Татварын хөнгөлөлт, Байгаль хамгаалагчийн цалин, цагдаагийн шатахуун гэх мэт/ хийгдсэн гүйлгээ шат шатанд нь тохируулж тайлагнадаггүйгээс нэмэлт санхүүжилтийн буюу бусад эх үүсвэр болон зардлыг өсгөж тайлагнадаг зөрчил нийтлэг байна.

- Сумд нь замын хуудас, маршрут бичилгүйгээр шатахуун олгохоор цохолт хийдэг, нярав сарын эцэст шатахуун олгох цохолт хийсэн бичгийг үндэслэн замын хуудас бичиж, шатахууны тайлан гаргадаг зөрчил ихээр байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1 “анхан шатны баримт нь НББүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчиж байна.
- Автомашины сэлбэг хэрэгсэл, урсгал засвар хийхдээ техникийн комиссын дүгнэлт шийдвэр гаргадаггүй, засварын ажлын хөлсийг гэрээ холбогдох баримт байхгүйгээр олгодог.
- Нүүрс нийлүүлэх гэрээг байгуулахдаа уурын зуухны зарцуулалтын норм нормативт хэмжээнээс хэтрүүлэн хийдэг, нүүрсний өдөр тутмын олголтыг бичдэггүй, бөөн дүнгээр шаардах хуудас бичиж зардалд бчидэг буюу зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байна

4.Мөнгөн хөрөнгийн талаар

Төв аймгийн 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдлын тайлангаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхэнд 5873.8 сая төгрөг, оны эцэст 5099.1сая төгрөг байхад мөнгөн гүйлгээний тайлангаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь оны эхэнд тохирсон ба оны эцэст 50.1 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн. Аудитын явцад алдааг залруулах санал болгосноор санхүүгийн байдлын тайланд залруулга хийгдснээр мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эхэнд 5873.8 мянган төгрөгөөр, жилийн эцэст 5124.1 сая төгрөгөөр нэгтгэсэн байна. Тодруулга тайлангаар 325.2 сая төгрөгийг Сангийн яаманд татан төвлөрүүлснийг цаг хугацааны давчуу байдлаас тулган баталгаажуулаагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг багцаар харуулахад: /сая төгрөг/

д/д	Дансны нэр	мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	
		2013.01.01 ны үлдэгдэл	2013.12.31 ны үлдэгдэл
1	Орон нутгийн багц	5873.8	5114.5
2	БШУЯам	0	1.7
3	Эрүүл мэндийн яам	0	6.5
4	ССАЖЯам		1.4
5	Барилга хот байгуулалтын яам	0	0.001
	БҮГД ДҮН	5873.8	5124.1

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулагдсан мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгуужуулахад:

✓ Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2013 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл 5873.8 сая төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар мөнгөн хөрөнгийн аудитлагдсан үлдэгдэл нийт 5872.9 сая төгрөгөөс 0.9 сая төгрөгний зөрүүтэй нэгтгэгдсэн байна.

✓ Мөнгөн хөрөнгийн жилийн эцсийн нийт үлдэгдлийг Баянжаргалан сумын ЭЭСангийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл /арилжааны банкны үлдэгдлийн баталгаагаар 0.9 сая төгрөг/ байхыг, тайлан гаргаж нэгтгүүлээгүй тул эхний хагас жилийн үлдэгдлээр буюу 3.7 сая төгрөгөөр, Сэргэлэн сумын ЭЭСангийн үлдэгдэл 1.5 сая төгрөгийг 1.0 сая төгрөгөөр буюу 0.5 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн байна. Иймд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 5121.8 сая төгрөгийг, 5124.1 сая төгрөгөөр буюу 2.3 сая төгрөгөөр илүү нэгтгэгдсэн байна.

Сумдын Төрийн сангийн төлөөлөгч, нягтлан бодогч, татварын байцаагч нар нь харилцах дансдын хуулгыг цаг хугацаанд нь боловсруулж үлдэгдлийг тухай бүрт тулгаж байгаагүйгээс Баян-Өнжүүл сум орлогын дансны эцсийн үлдэгдэл 4.9 сая төгрөгний 0.7 сая төгрөг юуны үлдэгдэл болох нь тодорхойгүй, Баянцагаан сум орлогын дансны эцсийн үлдэгдэл 13.4 сая төгрөгний 6.6 сая төгрөг нь урьд оны хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн үлдэгдэл санхүүжилт, Аргалант сумын орлогын дансны эцсийн үлдэгдэл 6.1 сая төгрөгний 0.6 сая төгрөг нь ОНХСанд шилжүүлэх хандивын орлого, Баянхангай сумын орон нутгийн орлогын дансны үлдэгдэл 5.4 сая төгрөгний 0.5 сая төгрөг нь буюу ХААН банкнаас андуурсан 0.2 сая төгрөг, СХСангийн зээлийн эргэн төлөлт 0.3 сая төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна.

Аудитаар Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам” –ын 6.3- д заасан заалтыг мөрдөж ажиллаагүйгээс Аймгийн Засаг даргын нөөц сангаас нийт 123.2 сая төгрөгийг, хуваарлагдаагүй зардлын данснаас 255.5 сая төгрөгийг бэлнээр авч зарцуулахдаа журмаар тогтоосон хэмжээг хэтрүүлэн нэг удаагийн авалтаар 0.4-34.2 сая төгрөгийг авсан нь Төрийн сангаас тавих хяналт сул байгааг харуулж байна.

5.Хөрөнгийн талаар

Төв аймгийн 2013 оны жилийн эцсийн залруулагдсан санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндсэн хөрөнгийн үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангаар оны эхэнд 28987.2 сая төгрөг байсан ба оны эцэст 90797.0 сая төгрөг болж, оны эхнээс 61809.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, Бараа материалын үлдэгдэл оны эхэнд 1209.1 сая төгрөг, оны эцэст 4084.4 сая төгрөг болж, оны эхнээс 2875.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө, бараа материал нь оны эхнээс ийнхүү нэмэгдсэн гол шалтгаан тусгай зориулалттай шилжүүлгийн байгууллагууд нэгтгэгдсэнтэй холбоотой байна. Тусгай зориулалттай шилжүүлгийн байгууллагуудын оны эхний хөрөнгийн үлдэгдлийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан гэж нэмж нэгтгэсэн байна.

Үндсэн хөрөнгө болон бараа материалын дансдын эцсийн үлдэгдлийг
хүснэгтээр харуулвал: /сая төгрөг/

д/д	Дансны нэр	бараа материал		үндсэн хөрөнгө	
		2013.01.01- ны үлдэгдэл	2013.12.31- ны үлдэгдэл	2013.01.01- ны үлдэгдэл	2013.12.31- ны үлдэгдэл
1	Орон нутгийн багц	1209.1	1429.1	28987.2	35347.0
2	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд		2655.3	0	55450.0
а	БШУЯам		1636.8		36180.0
б	Эрүүл мэндийн яам		458.6		8181.6
в	ССАЖЯам		533.8		9922.6
г	Барилга хот байгуулалтын яам		17.4		271.4
д	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	0	8.7		894.4
	БҮГД ДҮН	1209.1	4084.4	28987.2	90797.0

Дээрх судалгаанаас харахад 2013 оны жилийн эцсийн нийт үндсэн хөрөнгийн 55450.0 сая төгрөг буюу 61.1 хувийг, бараа материалын үлдэгдлийн 2655.3 сая төгрөг буюу 65 хувийг Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын хөрөнгө эзэлж байна.

Залруулагдсан тайлангаар бараа материалын эхний үлдэгдэл орон нутгийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитлагдсан эцсийн үлдэгдэл 1205.9 сая төгрөгнөөс 3.1 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн.

Аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн тайлагналтай холбогдон илэрсэн зарим асуудал:

- Бараа материалын тайланг эд хариуцагч нар нь цаг хугацаандаа гаргадаггүй, мөнгөн хөрөнгөнөөс шууд зардалд бичдэг.
- Хөрөнгийн тооллого тооцоог чанартай хийдэггүй, санхүүгийн программаас гаргасан хөрөнгийн тооллогын бүртгэлд тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурсан ба хөрөнгөтэй тулгалт хийсэн нотлох баримт байхгүй байна.
- Үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байгаа ч тухайн хөрөнгийг устгах устгалтын комисс томилсон шийдвэр, нотлох баримт байдаггүй.

6.Авлага, өр төлбөрийн талаар

Төв аймгийн 2013 оны жилийн эцсийн залруулагдсан санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн байдлын тайлангаар авлага оны эхэнд 3750.1 сая төгрөг байсан ба оны эцэст 8190.8 сая төгрөг болж, оны эхнээс 4440.6 сая төгрөгөөр нэмэгдсэн. 2013 оны жилийн эцсийн нийт авлагын 71 хувийг сум хөгжүүлэх сангийн авлага эзэлж байна.

Өглөгийн үлдэгдэл оны эхэнд 1357.5 сая төгрөг, оны эцэст 1883.1 сая төгрөг болж, оны эхнээс 525.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авлага, өглөгийн эхний эцсийн үлдэгдлийг яамдаар харуулбал: /сая төгрөг/

д/д	Дансны нэр	Авлага	Өглөг
-----	------------	--------	-------

ТӨВ АЙМГИЙН 2013 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БОЛОН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

	2013.01.01- ны үлдэгдэл	2013.12.31- ны үлдэгдэл	2013.01.01- ны үлдэгдэл	2013.12.31- ны үлдэгдэл
1 Орон нутгийн багц	3750.2	8148.7	1357.5	1658.8
2 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд	0	42.1	0.0	224.3
а БШУЯам		16.7		148.0
б Эрүүл мэндийн яам		7.1		14.3
в ССАЖЯам		18.1		20.0
г Барилга хот байгуулалтын яам		0.0	0.0	0.2
д Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам		0.2		41.9
БҮГД ДҮН	3750.2	8190.8	1357.5	1883.1

Авлагын тулган баталгаажуулалтаар авлагын эхний үлдэгдэл орон нутгийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитлагдсан эцсийн үлдэгдэл 3866.7 сая төгрөгнөөс 116.5 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн байна

Бэлтгэн нийлүүлэгч, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж актыг үйлдсэн боловч тооцооны баримтын жагсаалт буюу бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нийт төлсөн мөнгө болон нэхэмжилсэн дүнг тодорхой бичдэггүй, зарим сум байгууллагууд нь тооцоо нийлэхгүйгээр өр, авлагаа шууд хааж бичсэн, өр авлагагүй гэдгээр тооцоо нийлж акт үйлддэггүй зөрчил байна.

7.Тусгай зориулалтын сангийн талаар

Төв аймгийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 27 сумын 148 сан, аймгийн 9 сан нийт 157 тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан, Мал хамгаалах сан, Байгал хамгаалах сан, Байгал орчны нөхөн сэргээлтийн барьцаа сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын харилцах дансд нь Төрийн санд, Эм эргэлтийн сангийн харилцах данс нь арилжааны банкинд байршиж үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Байгал хамгаалах сан, Байгал нөхөн сэргээх барьцааны сан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангуудыг нэгтгэж тусгасан ба Баянцогт, Баянхангай сумдын ГХУССанг тус нэгтгэлд орхигдуулсан байна.

Сумдын тусгай зориулалттай сангуудыг тус бүрээр авч үзвэл:

Орон нутгийн хөгжлийн сан

Төсвийн тухай хуулийн 60-р зүйлд тусгасаны дагуу 2013 онд Орон нутгийн хөгжлийн санг сум бүрт шинээр байгуулж ажилласан ба санхүүжилт болон бусад их үүсвэрээс бүрдүүлсэн хөрөнгийг, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтанд зарцуулагдаж үндсэн хөрөнгийн дансанд тусгагдсан байна. Орон нутгийн хөгжлийн сангаас ард иргэдийн саналыг авч эрэмбэлэгдсэн

жагсаалтад ороогүй хөрөнгө оруулалтанд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна. Жишээлбэл Заамар суманд: Наадмын зардал 4.7 сая төгрөг, Бохирын шугам тавихад 1.7 сая төгрөг, Засаг дарга, ИТХурлын дарга нарын өрөөний засварт 8.6 сая төгрөг, Сургуулийн хашаа шинэчлэхэд 28.5 сая төгрөг, Баянбулгийн ванн засвар 15.5 сая төгрөг, Маршрутын самбар 2.1 сая төгрөг зэрэг тогтоолд заагдаагүй хөрөнгө оруулалтын ажилд зарцуулсан байна.

Мөн зарим суманд ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй байна. Жишээлбэл:

- Эрдэнэ сум малын үүлдэр угсааг сайжруулахаар 22.4 сая төгрөгийг зарцуулсан боловч малыг данс бүртгэлд тусгаагүй байна.
- Зуунмод суманд жишиг хороолол байгуулахад дэд бүтэц, хашааний үнэнд 70.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр өгсөн боловч авлагаар тусгаагүй байна.

Сум хөгжүүлэх сан

Сумдын “Сум хөгжүүлэх сан”-гаас зээл олгохдоо тэр болгон оновчтой биш төслийг санхүүжүүлдгээс болж авлага нэмэгддэг, ихэнх сум зээлийн зориулалт, эргэн төлөлтөнд тавих хяналт муу, зээл хариуцаж байгаа ажилтнууд зээлийн хүүгээ буруу тооцдог, зээл авсан иргэд суманд зах зээл байдаггүй, зээлээ эргэлтэнд оруулах боломжгүйгээс тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж чаддаггүй, зориулалтын бус зүйлд ашиглах зэрэг нийтлэг зөрчил байсаар байна. 2013 онд Сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1974.0 сая төгрөг байсан дээр 2183.6 сая төгрөгийн санхүүжилт, зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт 1883.4 сая төгрөг, нийт 4067.0 сая төгрөгийн орлого төвлөрсөнөөс 5094.8 сая төгрөгийн зээл буюу төслийн санхүүжилт олгож оны эцэст 650.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Оны эцэст 6028.4 сая төгрөгийн авлагатай байна. Жишээлбэл: 2013 онд Дэлгэрхаан сумын Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдэл 198.4 сая төгрөг, зээлийн хүү 58.0 сая төгрөг, нийт 204.2 сая төгрөгийг сангийн тайлан болон сумын нэгтгэсэн тайланд 26.2 сая төгрөгөөр буюу 178.0 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.

Мал хамгаалах сан

Сумдын Мал хамгаалах сан нь оны эхэнд мөнгөн хөрөнгө 98.8 сая төгрөг байсан дээр 141.2 сая төгрөгийн санхүүжилт авч 141.8 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 98.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Тус сангаас өвс, тэжээл бэлтгэх ажлыг санхүүжүүлэхдээ бэлтгэн нийлүүлэгчидтэй хийсэн гэрээнд өвс тэжээлийн үнэ, бүтээгдэхүүний чанар, тээврийн хөлс, хүргэх газар, бэлтгэн нийлүүлэх хугацаа зэргийг тодорхой тусгадаггүйгээс өвс тэжээлийн нэг бүрийн үнэ харилцан адилгүй байна. Мөн худалдаж, борлуулсан өвс, тэжээлийн үнийг төвлөрүүлэх, данс бүртгэлд авлага, өглөгөөр тусгах, бараа материалын тооцоог бодож үлдэгдэлийг данс бүртгэлд тусгах, тооллого хийж баталгаажуулах ажил хангалтгүй байна.

Байгал хамгаалах сан

Сумдын Байгал хамгаалах сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 61.3 сая төгрөг байсан дээр 305.0 сая төгрөгийн санхүүжилт авч 229.6 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 135.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Тус сангаас зарцуулагдаж байгаа зардлын дийлэнх хувийг шатахууны зардал эзэлдэг ба морин эргүүлийн урамшуулал, булгийн эх хаших, хог булж цэвэрлэх, хогын сав авах зэрэгт зарцуулсан байна. Шатахуун зарцуулалтанд ажил гүйцэтгэсэн тухай жолоочийн хуудсыг бөглүүлэх, ашигласан техникийн нормативаар шатахууны зарцуулалтыг тооцож баталгаажуулаагүй зөрчил нийтлэг байна. Зарим сумдад Хог хаягдлын татварын орлогын мөнгийг тус санд төвлөрүүлэн түүгээр зарцуулдаг, татварын орлогын тайланд тусгадаггүй зөрчил гарч байна.

Нөхөн сэргээлтийн барьцаа сан

Энэ санд тухайн суманд уул уурхай, ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө байршуулж, нөхөн сэргээлт хийсэний дараа тухайн мөнгөө буцаан авах журамтай байна. Сумдын нөхөн сэргээлтийн барьцаа сангийн санхүүгийн тайланд аудит хийхэд Нөхөн сэргээлтийн барьцаа мөнгийг Байгал хамгаалах санд орлогоор авч зарцуулдаг зөрчил байна. Мөн тус сангийн дансанд байгаа үлдэгдлийг аж ахуйн нэгж тус бүрээр задлаж бүртгээгүй, Зарцуулах тухай зөвшөөрөл ирээгүй байхад ямар нэгэн зардалд зарцуулдаг, нөхөн сэргээлтийг хийсэн тухай акт үйлддэггүй, барьцаа мөнгийг буцаан олгодоггүй зөрчилүүд байна. Аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Нөхөн сэргээлтийн барьцаа сангийн мөнгөн хөрөнгийг, Байгал хамгаалах сантай нэгтгэн тайлагнасан ба аудитаар тус сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 83.2 сая төгрөг дээр орлого 38.0 сая төгрөг, зарлага 15.0 сая төгрөг, оны эцсийн үлдэгдэл нь 113.1 сая төгрөг байхаар тооцлоо.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан

Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл нь 24.6 сая төгрөг ба 68.0 сая төгрөгийн орлого төвлөрч 72.1 сая төгрөгийг зарцуулан оны эцэст 17.5 сая төгрөг үлдсэн байна. Аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд ГХУССангийн мөнгөн хөрөнгийг Байгал хамгаалах сантай нэгтгэн тайлагнасан байна. ГХУССангийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу “шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх” гэсэн байхад зарим суманд ГХУССан байхгүй үйл ажиллагаа явуулаагүй байна. Жишээлбэл: Алтанбулаг, Баян-Өнжүүл, Сүмбэр, Сэргэлэн сумдууд нь тухайн зардлыг ГХУС сангаар дамжуулахгүй зарцуулж байна.

Эмийн эргэлтийн сан

Эмийн эргэлтийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 103.5 сая төгрөг, оны эцэст 124.8 сая төгрөгний үлдэгдэлтэй тайлагнагдсан боловч аудитаар Баянжаргалан сумын ЭЭСангийн санхүүгийн тайлан гаргаж нэгтгэгдээгүй учир дээрх үлдэгдэл нь баталгаажуулаагүй болно. ЭЭСангийн Баянжаргалан сумын тайлан нэгтгэгдээгүйгээс эмийн үлдэгдэл болон, авлагын үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй байна. ЭЭСангийн санхүүгийн тайланд аудит хийх явцад санхүүгийн тайланг программаар гаргадаггүй, баркод уншигчийг ашигладаггүй, борлуулалтын орлогоос ЭМТөвийн урсгал зардалд зарцуулдаг, хувь хүмүүст зээлээр эм олгож авлага үүсгэдэг зөрчлүүд нилээд хувийг эзэлж байна. Жишээлбэл: Баян, Борнуур, Заамар, Мөнгөнморьт зэрэг сумдууд нь эм эргэлтийн сангаас сумын ЭМТөвийн урсгал зардалд зарцуулсан байна.

Аймгийн тусгай зориулалттай сангуудыг тус бүрээр авч үзвэл:

Аймаг хөгжүүлэх сан

Тус санд 2013 оны 1-р сарын 1-нд 251.9 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна. Тайлант онд зээл, зээлийн хүү нийт 80.7 сая төгрөг орсон ба Эрдэнэсант, Баянчандмань, Өндөрширээт, Дэлгэрхаан сумдад 220.0 сая төгрөгний санхүүжилт, Мах боловсруулах үйлдвэрт 50.0 сая төгрөгний зээл, Бүрэн Өрнөх ХХК-д 25.0 сая төгрөгний зээл, Төв-Чандмань ДЭХГазарт 31.0 сая төгрөгний зээл олгож, нийт 326.0 сая төгрөгний зарлагын гүйлгээ хийгдсэн байна. Тус сан 2014 оны 1-р сарын 1-ний байдлаар 6.7 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Аймаг хөгжүүлэх сан нь 2013 оны 1-р сарын 1-ний байдлаар аймгийн Төв-Чандмань ОНӨҮГазраас 76.9 сая төгрөг, Зуунмод Мах боловсруулах үйлдвэрээс 115.7 сая төгрөг, Долгион төв ХХК-иас 61.2 сая төгрөг, Бүрэн Өрнөх ХХК-аас 25.2 сая төгрөг, нийт 279.0 сая төгрөгний авлагатай байна.

Долгион төв ХХК, Бүрэн Өрнөх ХХК, Зуунмод Мах боловсруулах үйлдвэрийн хүүгийн авлагыг 3.3 сая төгрөгөөр дутуу тооцож тайлагнасан байна.

Төв Чандмань ДЭХГазарт жишиг хорооллын хашаа, гудамж, талбайг тохижуулахад зориулж 31.0 сая төгрөгний зээлийг хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр өгсөн байна. Гэвч уг зээлийг авсан Төв Чандмань ДЭХГ нь тус Аймгийн хөгжлийн сангаас 2011 онд авсан зээлээс 5.8 сая төгрөг, 2012 онд авсан зээлээс 40.0 сая төгрөгний үлдэгдэлтэй байгаа нь “Аймгийн хөгжлийн сангийн журам”-ын 4.6.в, 4.6.д заалтуудыг зөрчиж байна.

Аймгаас Мах боловсруулах үйлдвэрийг дэмжих зорилгоор тус сангаас 65.7 сая төгрөгний зээлийг жилийн 1 хувийн хүүтэйгээр 36 сарын хугацаагаар, эхний 12 сард үндсэн зээлийг төлөхгүй зэрэг хөнгөлөлттэй нөхцлөөр 2012 оны 1-р сард олгосон байна. Энэ аж ахуйн нэгж 2013 онд 106.5 сая төгрөгний борлуулалт хийж, үйл ажиллагааны 141.9 сая төгрөгний зардал гаргаж, 54.6 сая төгрөгний үйл ажиллагааны алдагдалтай ажилласан нь цаашид үлдэж байгаа 1 жилд зээлийг хугацаанд нь бүрэн төлөх нь эргэлзээтэй байдалд орсон байхад нэмж оны эцэст 50.0 сая төгрөгний зээл олгосон байна. Иймд энэ ОНӨҮГазрын үйл ажиллагаанд аймгаас хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан

Аймгийн ИТХурлын 2012.12.14-ны хуралдаанаар аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр орлогын шилжүүлэгээр 9000.3 сая төгрөг, зарлагыг сумдын ОНХсанд олгох орлогын шилжүүлэг 5400.1 сая төгрөг аймгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 3694.2 сая төгрөгөөр батлагдсан байна. Төв аймгийн ИТХурлын 2013.12.03-ны өдрийн хуралдаанаар аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр орлогын шилжүүлэгээр 7621.6 сая төгрөг, хандив тусламжийн орлого 1090.1 сая төгрөг, зарлага сумдын ОНХсанд олгох орлогын шилжүүлэг 4573.1 сая төгрөг аймгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 4138.6 сая төгрөгөөр тодотгон батлагдсан байна.

ОНХөгжлийн сангийн эх үүсвэр тодотгосноор 7621.6 сая төгрөгийн орлогын шилжүүлэг, 1090.1 сая төгрөгийн хандив нийт 8711.7 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 7580.5 сая төгрөгийн эх үүсвэр бүрдэж батлагдсанаас 1131.2 сая төгрөгийн дутуу санхүүжигдсэн байна.

Тайлант онд Хөгжлийн сангийн дансанд орсон орлогыг ангилвал орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэн орлого 6924.1 сая төгрөг, 90-н жилийн ойн хандив 506.6 сая төгрөг, Замын сангаас 8.7 сая төгрөг, Орон нутгийн хуваарилагдаагүй зардлаас 26.5 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаас 90.0 сая төгрөг, Монголын морин спортын хорооноос 5.0 сая төгрөг, бусад 19.4 сая төгрөг нийт 7580.5 сая төгрөгийн орлого орсон байна.

Тайланд онд ОНХөгжлийн сангийн данснаас сумдын орон хөгжлийн сангийн дансанд 3686.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, аймгийн хөрөнгө оруулалтын ажилд 2651.6 сая төгрөг, ГХБХБАлбанд техник хяналтын зардалд 21.5 сая төгрөг, 90-н жилийн ойн арга хэмжээний зардалд 654.1 сая төгрөг, орон нутгийн хуваарилагдаагүй дансанд 5.0 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтын дансанд 0.5 сая төгрөгийг шилжүүлж нийт 7018.4 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 562.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Байгал хамгаалах сан

Байгал хамгаалах сан 2013 оны 1-р сарын 1-ны байдлаар 24.3 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тус санд Аймгийн ИТХурлын 05 тоот тогтоолоор 1271.2 сая төгрөг зарцуулах эрхийг баталснаас орлого буурсантай холбогдуулан төсвийн тодотгол хийж 900.2 сая төгрөг зарцуулахаар баталж, гүйцэтгэлээр 627.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

БХСанд тайлант онд 627.4 сая төгрөгийн санхүүжилт, хандив 4.0 сая төгрөг, түрээсийн төлбөр 10.1 сая төгрөг, нийт 641.5 сая төгрөгийн орлого орж, 2013 онд тус сангаас нийт 629.9 сая төгрөгний зардал гаргаж, 35.9 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Байгал хамгаалах сангаас Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр 311.5 сая төгрөг, Ойн нөхөн сэргээлт ойжуулалтын арчилгаа, цөлжилтийн төлөв байдлын судалгаа, цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадасны нөлөөг нэмэгдүүлэх зэрэгт 163.3 сая төгрөг, Хөрсний бохирдлыг багасгаж иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах зорилгоор ариун цэврийн байгууламжтай ажлыг эхлүүлэхэд 140.0 сая төгрөг, Байгал хамгаалагч нарын сургалт семинарын зардалд 3.0 сая төгрөг, Байгал хамгаалах нөхөн сэргээх

ажлын хүрээнд экологийн танхим байгуулах болон биотехникийн арга хэмжээнд 12.3 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Хүүхдийн төлөө сан

Хүүхдийн төлөө санд 2013 оны 1-р сарын 1-ны байдлаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4.6 сая төгрөг, 0.2 сая төгрөгний хандив орж, БНСУ-д зохиогдсон хүүхдийн урлагийн Их наадамд оролцох замын зардлын дэмжлэг 0.5 сая төгрөг, Баянчандмань суманд алга болсон хүүхдийн ар гэрт тусламж 0.1 сая төгрөг тус тус зарцуулж, 4.2 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тариалан дэмжих сан

Тариалан дэмжих санд 2013 оны 1-р сарын 1-нд 60.6 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, тайлант онд 2.0 сая төгрөг нь Цээл сумын Хөндлөн хангай ХХК-аас зээлийн төлбөр, М.Ганбат, Д.Толя нараас 11.9 сая төгрөгний зээлийн төлбөр, нийт 13.9 сая төгрөгний орлого орж, ургац хураалтын ажиллагааг эрчимжүүлэхэд 1.1 сая төгрөг, Угтаал сумын сум хөгжүүлэх санд 23.0 сая төгрөгийг зарцуулж, 49.8 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тариалан дэмжих сан нь 2013 оны 1-р сарын 1-ны байдлаар 18 аж ахуйн нэгж, иргэнээс 49.8 сая төгрөгний авлагатай байснаас 2 аж ахуйн нэгж, иргэнээс 2.0 сая төгрөгний зээлийг төлүүлж, 47.8 сая төгрөгний авлагатай байна. Дээрх аж ахуйн нэгж, иргэд нь сангаас авсан зээлээ хугацаанд нь төлөөгүйгээс Шүүхийн шийдвэрээр хүүг зогсоосон байна. Тариалан дэмжих сангийн авлагын үлдэгдэлийг 8.6 сая төгрөгөөр бууруулан тайлагнасан зөрчил илэрлээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санд 2013 оны 1-р сарын 1-нд 2.1 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, тайлант онд аймгийн ИТХ-аас 20.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, 19.2 сая төгрөгний зардал гаргаж, 3.1 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тус сангаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг амжилттай зохион байгуулсан байгууллага, хувь хүмүүст урамшуулал 3.3 сая төгрөг, сургалт семинар, уралдаан тэмцээнд 14.4 сая төгрөг, архины зөвшөөрөл хэвлүүлэхэд 0.5 сая төгрөг, Ахмадын хороонд 1.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Мал хамгаалах сан

Мал хамгаалах санд 2013 оны 1-р сарын 1-ны байдлаар 15.7 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. 2013 онд тус санд нийт 7.4 сая төгрөгний орлого, нийт 8.4 сая төгрөг зарцуулж 14.7 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Мал хамгаалах сан 2013 оны эхэнд 7 иргэн, аж ахуйн нэгжээс 89.8 сая төгрөгний авлагатай байсан бол тайлант онд бодогдсон хүүгээр 0.3 сая төгрөгний авлага нэмэгдэж, зээл, хүүгээр 1.3 сая төгрөг төлөгдөж, оны эцэст 88.8 сая төгрөгний авлагатай байна.

Өглөг оны эхэнд 69.0 сая төгрөг байсан нь оны эцэст өөрчлөгдөөгүй байна.

2-н иргэний 69.0 сая төгрөгний авлагыг барагдуулахад онцгой анхаарч ажиллах, улсын Мал хамгаалах санд энэ хүмүүсийн төлбөр хийгдсэн эсэх талаар хандаж, албан ёсны хариуг бичгээр авсны үндсэн дээр төлбөрийг төлүүлэх талаарх арга хэмжээг авах, мөн “Төв хөгжил сан”-гаас шилжиж ирсэн 15.0 сая төгрөгний авлагыг барагдуулах талаар хуулийн байгууллагад хандаж тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Соёл, урлаг хөгжүүлэх сан

Тус санд 2013 оны 1-р сарын 1-ны байдлаар 0.34 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, тайлант онд шагналын үлдэгдэл 0.06 сая төгрөг, 5.1 сая төгрөгийн санхүүжилт орсон байна. 90-н жилийн ойн хүрээнд аймгийн тухай дуу хийсэн хамтлагийн 4 залууд дэмжлэг 0.4 сая төгрөг олгож, 5.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн нөөц сан

Засаг даргын нөөц санд 237.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 233.8 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төлөвлөгөөнөөс 3.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна. Мөн тус санд үндсэн үйл ажиллагааны орлогоор 30.9 сая төгрөг орсныг ангилвал аймгийн 90-н жилийг угтан аймгаа алдаршуулсан Мянгатууд арга хэмжээнээс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон 29.4 сая төгрөг, Аэрмаркет ХХК-аас тийзний үнийн зөрүү 1.5 сая төгрөг тус тус орсон байна.

Тус сан нь 2013 оны эхэнд 0.36 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, тайлант онд 264.8 сая төгрөгийн орлого орж 265.1 сая төгрөгний зарлага гарч, оны эцэст үлдэгдэлгүй байна. Засаг даргын нөөц сангийн зарцуулалтыг бүтцээр нь авч үзвэл: Буцалтгүй тусламж, дэмжлэгэнд 11.0 сая төгрөг, сургалт, сурталчилгаа, семинар зөвлөгөөнд 36.2 сая төгрөг, шагнал урамшил, бэлэг дурсгалд 57.9 сая төгрөг, гадаад томилолтонд 11.3 сая төгрөг, баяр наадам, ой тэмдэглэхэд 49.0 сая төгрөг, спортын болон бусад уралдаан тэмцээнд 5.8 сая төгрөг, малын тоо, цэрэг татлага, ойн түймэрээс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах ажилд 48.7 сая төгрөг, хүлээн авалтын зардалд 34.2 сая төгрөг, бусад зардалд 10.9 сая төгрөг зарцуулжээ.

Хүлээн авалт хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулахдаа Засгийн газрын 1999 оны 198 тоот тогтоолоор батлагдсан Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын нормативын 2-т “... аймаг, нийслэлийн Засаг дарга...тэдгээртэй адилтгах албан тушаалтнаас гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд хийх хүлээн авалтын нэг хүнд ногдох зардал нь 10 хүртэл хүн оролцоход 12000 төгрөг, 50 хүртэл хүн оролцоход 10000 төгрөг, 50-иас дээш хүн оролцоход 8000 төгрөгөөс тус тус илүүгүй байна.”, Мөн 3-т “Энэхүү хавсралтын 2 дугаар зүйлд заасан “хүлээн авалтын арга хэмжээнд архи хэрэглэхийг хориглоно” гэснийг зөрчиж тогтоосон нормативаас хэтрүүлэн хүлээн авалт хийж, хориглосон заалтыг зөрчиж 14 арга хэмжээнд 2.9 сая төгрөгийн архи согтууруулах ундаа хэрэглэсэн байна.

Гадаад дотоодын зочин төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зүйл гардуулахдаа Засгийн газрын 1999 оны 198 тоот тогтоолоор батлагдсан Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журамын 4-т “...аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээртэй адилтгах албан тушаалтнаас тухайн

салбар, чиглэлийн шугамаар албан ёсны айлчлал хийж буй ижил зиндааны гадаадын зочин, төлөөлөгчдөд нэг хүнд 50000 төгрөг, албан айлчлалын бус үеийн гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд нэг хүнд 40000 төгрөгөөс тус тус илүүгүй үнэтэй зүйл байхаар тооцох...” гэснийг зөрчин тогтоосон нормативаас хэтрүүлэн тогтоосон хэмжээнээс 5-10 дахин үнэтэй мөнгөн аяга, бусад бэлэг дурсгалын зүйлд 4.6 сая төгрөгийг зарцуулж төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчил илэрлээ.

Гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд гардуулах бэлэг дурсгалын зүйлийн нөөцөнд гэж 10 ширхэг мөнгөн аяга 2.6 сая төгрөг, 10 ширхэг фото зураг 0.5 сая төгрөг, хадаг, ааруул, бичиг бичүүлэхэд 0.2 сая төгрөг, нийт 3.3 сая төгрөгийг бэлнээр гаргаж хөрөнгийг зарцуулахдаа нярав орлого авалгүйгээр, эрх бүхий албан тушаалтны хөрөнгө зарцуулахыг зөвшөөрсөн шийдвэргүйгээр зарцуулсан зөрчил илэрлээ.

Аймгийн Засаг даргын №А/503 тоот захирамжаар эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгосон Онцгой комиссын гишүүдийн хувцасны үнэ 3.2 сая төгрөгийг хувцасны үнийг төлүүлээгүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зөрчил илэрлээ.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Хоёр: Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараахь заалтад хураангуйлан тэмдэглэв. Аймгийн Засаг даргаас 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2014 оны 4-р сарын 8-нд ирүүлсэн тул аудит хийх хугацаа шахуу байсан. Мөн анхны ирүүлсэн тайлангийн уялдаа холбоос буруу, материаллаг их хэмжээний алдаатай байсныг залруулж дахин тайланг гаргаж ирүүлсэн.

- ✓ Орон нутгийн орлого эх үүсвэрийг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг хянан тайлагнах ба Татварын хэлтсийн мэдээ тайлантай зөрүүтэй байгаа зөрчлийг арилгах
- ✓ Санхүүгийн тайлангийн орлого, зардлын үзүүлэлтүүд багана мөрийг зөв сонгож зардлыг үнэн зөв тайлагнаж байх
- ✓ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу аривлан хэмнэлттэй зарцуулах
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах
- ✓ Засаг даргын нөөц санд цаг үеийн шинжтэй арга хэмжээнд зардлыг дүнгээр батлаж, орон нутгийн хөгжлийн санд хөрөнгө оруулалтын талаарх зардлыг нэр төрлөөр баталж байхад давхар хувиарлагдаагүй зардал нэртэйгээр зардал баталж зарцуулдаг явдлыг таслан зогсоох

Гурав: Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 50929.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 49729.5 сая төгрөгийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан болно.

Дөрөв: Тайлбар мэдүүлгийн захидал

Аймгийн аудитын газар аудит хийхдээ СТСХэлтсийн удирдлагын зүгээс гаргасан санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлд тулгуурлав. Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар тухайн байгууллагын санхүүгийн ажилтнуудаас тайлбар тодруулга авч бэлтгэсэн менежментийн захидлыг 2014 оны 4 дугаар сарын 21-ны өдрийн 03/83 тоотоор аймгийн Засаг дарга болон СТСХэлтэст хүргүүлж, аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ Санхүү төрийн сангийн хэлтсийн даргаас эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Тав: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн явц байдал, мэдээ тайлан гаргалт, түүнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж татварын мэдээ, санхүүгийн нэгтгэсэн тайлан хоёрыг зөрүүтэй гаргаж байгаа дутагдлыг арилгах
- ✓ Сумдын эмийн эргэлтийн сангуудад авсан НББүртгэлийн программ болон бараа материалын код уншигч төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа тул дахин хэрэгжүүлэхээр зөвлөмж өгөгдлөө.

Зургаа : Аудитын санал дүгнэлт

Төв аймгийн Аудитын газраас 2013 оны 12 дугаар сарын 31–нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

О.АМАРЖАРГАЛ

Т.МАЙЦЭЦЭГ

Ц.БАЗАРСАД

Ц.САРАНЧИМЭГ

Огноо 2014.04.19